


БАТЛАВ.
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА



Ж.ЦОЛМОН

ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВАХ,
ДАМЖУУЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-01		
Баталсан огноо:	2025 он- 10 сар- 20 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр И.Наранхүү	Огноо 2025. 10.19	Гарын үсэг
Боловсруулсан:	Албан тушаал, нэр П.Бэрэтшигч	Огноо 2025.10.19	Гарын үсэг

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025 10.15	
2					
3					

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВАХ,
ДАМЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид АХОЗШША гэнэ)-нд агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх бүх мэдэгдлүүдийг бичгээр болон мэдээлэл хүлээн авахад зориулагдсан цахим хуудас, шуудан, утас, холбоо мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүлээн авах, бүртгэх, дамжуулах, шинжлэн шалгах ажиллагаа явуулахад шаардагдах мэдээллийн санг бүрдүүлэх ажиллагааг зохицуулна.

Хоёр. Осол, зөрчлийн мэдэгдэл авах үйл ажиллагаа

2.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх мэдэгдлийг утсаар болон бусад мэдээллийн хэрэгслээр хүлээн авсан шинжлэн шалгагч нь дараах арга хэмжээг авна.

2.1.1. Мэдэгдэл хүлээн авсан шинжлэн шалгагч нь 'Осол, зөрчлийн мэдээлэл авах, дамжуулах жижүүрийн ажиллах журам'-ын "Б" хавсралтаар батлагдсан хүснэгтийг бөглөж даргад танилцуулна.

2.1.2. Мэдэгдлийг шалгах шаардлагатай бол шалгаж, шалгасан тухайгаа эргэж даргад мэдэгдэнэ.

2.1.3. Мэдэгдлийг мэдээлэл хариуцсан ажилтанд заавал танилцуулна.

2.1.4. Мэдэгдэл бичгээр авсан тохиолдолд бүртгэл, судалгааны мэргэжилтэн нь бичиг хэрэг хөтлөх ба тогтсон журмын дагуу ажиллана.

2.1.5. Авсан мэдээллээ баримттай нь хамт жижүүр шинжлэн шалгагчаас хүлээн авч гарын үсэг зуруулна.

Гурав. Мэдэгдлийг бүртгэх

3.1. Мэдэгдэл бичгээр болон цахим хэлбэрээр авсан тохиолдолд бүртгэл, судалгааны мэргэжилтэн нь бичиг хэрэг хөтлөн бүртгэнэ.

3.2. Бүртгэж авсан мэдэгдлийг албаны даргад тайлагнаж мэдээллийн санд бүртгэх үгүйг шийднэ.

3.3. Шинжлэн шалгагч нар нь бүртгэх мэдэгдлийг бүртгэл, судалгааны мэргэжилтэнд өгч осол, зөрчлийн мэдээллийн дагуу үндсэн санд файл үүсгэж, нэмж бүртгүүлнэ.

3.4. Бүртгэл хариуцсан ажилтан нь Мэдэгдлийг, өгөгдлийн санд ашиглалтын зааврын дагуу үнэн зөв оруулах, орсон мэдээллүүдийг хянах, ангилах, нэмэлт өөрчлөлт оруулах ажиллагааг системийн ашиглалтын зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.5. Мэдээллийн санд өгөгдөл нэмж оруулах, өөрчлөлт хийх, өгөгдлийг сангаас хасах ажиллагаа хийгдсэн тохиолдол бүрд уг үйлдлийг гүйцэтгэсэн хүн энэ тухайгаа системийн бүртгэлд бүртгүүлнэ.

Дөрөв. Мэдэгдлийг дамжуулах, хадгалах,

4.1. АХОЗШША-нь Чикагогийн Конвенцын 13 дугаар хавсралтад заасны дагуу осол, ноцтой зөрчил болон шинжлэн шалгах шаардлагатай зөрчлийн талаар холбогдох улсуудын шинжлэн шалгах байгууллагад саадгүй, боломжит хамгийн шуурхай арга хэрэгслээр мэдэгдлийг 'Осол, зөрчлийн мэдээлэл авах, дамжуулах жижүүрийн ажиллах журам'-ын "Б" хавсралтын маягтын дагуу хүргүүлнэ.

4.2 Агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой аливаа Мэдэгдлийг АХОЗШША-ны даргын шийдвэрийн дагуу гадны байгууллагад, шаардлагатай бол ICAO-д илгээнэ.

4.3. Гадаад улсаас осол, ноцтой зөрчлийн талаар мэдэгдэл хүлээн авсны дараа Монгол Улс нь бүртгэлийн улс, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн хувиар тухайн улсад байгаа холбогдох мэдээллийг (нисэх баг, аюултай бараа, зохион бүтээгч, үйлдвэрлэгчтэй холбоотой мэдээлэл)-ийг цаг алдалгүй хүргүүлнэ.

4.4 Хэлэлцэн тохиролцогч бус улсын нутаг дэвсгэрт, эсхүл аль ч улсын харьяалалгүй бүсэд гарсан осол, ноцтой зөрчлийн талаар Монгол Улс нь Чикагогийн Конвенцийн 13 дугаар хавсралтад заасны холбогдох улсад албан ёсны мэдэгдэл хүргүүлнэ.

4.5. Тохиолдол болсон улс нь тухайн осол, ноцтой зөрчлийн талаар мэдээгүй тохиолдолд Монгол Улс тухайн тохиолдол болсон улсад албан ёсны мэдэгдэл хүргүүлнэ.

4.6. Осол, зөрчилтэй холбоотой мэдэгдэл явуулахдаа ямар хэлбэрээр, хэнд явуулсан тухай бичиг хэрэг хөтлөх ба хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулна.

4.7. Шинжлэн шалгах ажиллагаа дууссаны дараа тайланг файлаар нь, бичиг хэргийн байдлаар, CD дээр хуулж хадгална.

4.8. Бүртгэл хариуцсан ажилтан нь бүртгэсэн мэдээллүүдийг дамжуулах, илгээх, нууцлах, хадгалах ажиллагааг системийн ашиглалтын зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

4.9. АХОЗШША нь нислэгийн осол, зөрчлийн талаарх Мэдэгдлийг хурдан шуурхай авах үйл ажиллагааг хангах зорилгоор, мэдээлэл авах хаяг, утасны дугаар, цахим хуудасны нэр, бусад мэдээлэл авч болох сувгийн талаар зар сурталчилгаа, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд зарлана.

Тав. Ажлын байрны бэлтгэл

5.1. Агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой аливаа Мэдэгдлийг дараах хаягаар хүлээн авна. Үүнд.

- осол, зөрчлийн мэдээлэл хүлээн авах, бүртгэх, илгээх давтамж

- Ажлын цаг 8-17 цаг

- Цахим шуудан: aaib@aaib.gov.mn

- Цахим хуудас: www.aaib.gov.mn

- Утасны дугаар /24 ц/: +(976) - 9595-3399

PROCEDURE FOR RECEIVING
AND FORWARDING ACCIDENT/INCIDENT NOTIFICATIONS
Appendix H

AAIB IN MONGOLIA		Initial Incident Report No.
1. 1. Aircraft Data Model/Serial: Operator/Owner: Nationality: Registration No.:		
2. 2. Flight Data Date: Occurrence Time: Occurrence Station: Flight No.: Departure/Destination Point: Captain:		
3. 3. Injured Persons on Board Yes <input type="checkbox"/> No <input type="checkbox"/>		
4. 4. Number of Crew and Passengers Crew: Passengers:		
5. 5. Nature of Condition (check one or more)		
Engine	Failure of one or more engines Failure of the propeller control system Fuel flow drop/fuel leak Fire in flight/on ground Engine shutdown	Flammable liquid leak Oil leak Warning indication Engine power loss
System breakdowns that did not interrupt the flight	Difficulty operating landing gear Electrical power loss Tyre burst Bird strike Loss of braking effectiveness	Fluid loss Overtemperature Multiple failures Warning indication
Loss of a system or indication vital to airworthiness and safety	Flight control system <input type="checkbox"/> Pressurization and air-conditioning system Pitch and heading indication system Airspeed and altitude system/indicators	Malfunction of escape slide deployment De-icing system <input type="checkbox"/> Flame/Smoke <input type="checkbox"/>
Other effects on flight	FOD <input type="checkbox"/> Go-around <input type="checkbox"/> Lightning strike Ground turn-back Air turn-back	Vibration/Buffer <input type="checkbox"/> Load factor <input type="checkbox"/> Rejected takeoff Precautionary landing <input type="checkbox"/> Emergency descent <input type="checkbox"/>
6. Stage (check one) <input type="checkbox"/> Maintenance <input type="checkbox"/> Landing <input type="checkbox"/> Take-off <input type="checkbox"/> Cruise <input type="checkbox"/> Approach <input type="checkbox"/> Towing/taxi <input type="checkbox"/> Climb <input type="checkbox"/> Other <input type="checkbox"/> Descent <input type="checkbox"/> Engine start		
7. Please fully describe the incident and the extent of damage to the aircraft, insofar as known, and, if available, provide details of any explosives, radioactive materials, or other dangerous goods carried.		
(Please attach additional pages as necessary.)		
Reported by:	Organization name:	Date (report received):
Phone number:	Email:	Address:
Name of Duty Manager:		Date: